

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

/2021 оны жилийн эцсийн байдлаар /

2022.01.12

Дархан-Уул

## **Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй**

Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийг хяналтанд авсан зүйл, заалттай харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, үүрэг болгосон зүйл, заалтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд үнэлгээний зорилго оршино.

Хяналтанд авсан Монгол Улсын хууль, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий Сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) –ийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн цэсэнд байршсан 88 шийдвэрийн 152 заалт, журмын 4.4-т заасны дагуу Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэж ирүүлсэн тайланг уншин “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5 дугаар бүлгийн 5.1.2-т заасны дагуу боловсруулалтыг сайжруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамаарах мэдээлэл, баримт, материалыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, соёл урлагийн газар, Мэдээлэл технологийн албаны асуудлыг хариуцсан албан хаагчдаас тодруулга авах, санал солилцох, ярилцлагын аргаар, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаас өгсөн 1 саналыг тусган гүйцэтгэлээ.

Хяналтанд авсан шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.3 дахь заалтын дагуу 5 шатлалт арга зүйгээр, шийдвэрийн зүйл, заалтын гүйцэтгэлийн үр дүнг хувиар тооцож гаргалаа.

## **Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

2021 оны жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг дарга хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

- ✓ Монгол Улсын 8 хуулийн 27 заалт,
- ✓ УИХ-ын 2 тогтоолын 2 заалт,
- ✓ УИХ-ын байнгын хорооны 3 тогтоолын 4 заалт,
- ✓ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 4 зарлигийн 10 заалт,
- ✓ ҮАБЗ-ийн 6 зөвлөмжийн 15 заалт,
- ✓ Засгийн газрын 45 тогтоолын 67 заалт,

- ✓ Ерөнхий Сайдын 1 захирамжийн 1 заалт,
- ✓ Засгийн газрын хуралдааны 19 тэмдэглэлийн 26 заалт, нийт 88 шийдвэрийн 152 заалтыг хяналтанд аван хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

2021 онд хяналтад авсан шийдвэрийн болон заалтын тоог хагас, бүтэн жилээр харуулбал:

Он	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Үнэлгээ
2021-II	67	126	76.67%
<b>2021-IV</b>	<b>88</b>	<b>152</b>	<b>94.61%</b>
Нийт /давхардсан тоогоор	155	278	

### Гурав. Үнэлгээний дүгнэлт

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр 2021 оны жилийн эцсийн байдлаар **94.61** хувийн хэрэгжилттэй **4.73** онооны үнэлгээтэй байна

### Холбогдох шийдвэрийн төрөл тус бүрээр харуулбал:

№	Биелэлт	Нийт	Шийдвэрийн төрөл								
			МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	Засгийн газрын тогтоол	Ерөнхий Сайдын захирамж	Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл	
1.	Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	<b>88</b>	8	2	3	4	6	45	1	19	
2.	Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо	<b>152</b>	27	2	4	10	15	67	1	26	
3.	Үүнээс	Бүрэн хэрэгжсэн 100% (90-100%)	<b>121</b>	18	1	4	8	15	53	-	22
		Хэрэгжих шатанд 70% (50-89%)	<b>16</b>	4	1	-	2	-	5	1	3
		Хэрэгжилт хангалтгүй 30% (10-49%)	<b>4</b>	-	-	-	-	-	3	-	1
		Хэрэгжээгүй 0% (0-9%)	<b>-</b>	-	-	-	-	-	-	-	-
	Хугацаа болоогүй	<b>11</b>	<b>5</b>	-	-	-	-	6	-	-	
Хэрэгжилтийн ерөнхий дүн, хувь		<b>94.61% буюу 4.73 оноо</b>	94.54% буюу 4.72 оноо	85.0% буюу 4.25 оноо	100% буюу 5.0 оноо	94.0% буюу 4.70 оноо	100% буюу 5.0 оноо	94.09% буюу 4.70 оноо	70.0% буюу 3.50 оноо	93.84% буюу 4.69 оноо	

2017-2020 онуудад хяналтад авсан шийдвэрийн төрлийг харьцуулж харуулбал:

(тухайн жилийн эцсийн байдлаар)

Он	Заалт, тоо	Нийт шийдвэрийн төрөл, үүнээс									
		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	Засгийн газрын тогтоол	Ерөнхий Сайдын захирамж	Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	ЗГХЭГ-ын даргын тушаал
2017	107	0	0	3	4	3	58	0	27	12	0
2018	149	2	3	3	7	3	74	5	24	13	15
2019	99	1	1	3	2	0	60	4	16	8	4
2020	182	23	1	4	4	8	95	1	23	24	0
<b>2021</b>	<b>152</b>	<b>27</b>	<b>2</b>	<b>4</b>	<b>10</b>	<b>15</b>	<b>67</b>	<b>1</b>	<b>26</b>	<b>0</b>	<b>0</b>

Дээрх хүснэгтээс харахад тухайн жилд хяналтад авсан нийт заалтын:

2017 онд 58 буюу 54.20%

2018 онд 74 буюу 49.66%

2019 онд 60 буюу 60.60%

2020 онд 95 буюу 52.19%

2021 онд 67 буюу 44.07%-ийг Засгийн газрын тогтоол буюу асуудлыг хамтран хэлэлцэж шийдвэрлэх үндсэн дээр баталсан баримт бичгийн заалтууд эзэлж байна.

2020-2021 онуудын хувьд:

- Монгол Улсын хэмжээнд бүх нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр баталсан Монгол Улсын хууль,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд нийцүүлэн баталсан зарлиг,
- Үйл ажиллагааг сайжруулах, аливаа бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зөвлөсөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж зэрэг захирамжлалын болон зохион байгуулалтын шийдвэрийн заалтууд нэмэгдсэн бол
- Хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд баталсан ЗГХЭГ-ын даргын тушаалын заалтууд хасагдсан байна.

### Холбогдох зохицуулалтын салбараар нь харуулбал:

№	Биелэлт	Нийт	Зохицуулалтын салбар									
			Ерөнхий чиг үүргийн салбар	Байгаль орчин аялал жуулчлал, уул уурхай	Батлан хамгаалах, гамшгаас урьд-сэргийлэх	Санхүү төлөвлөлт, хөрөнгө оруулалт	Хууль эрх зүй	Нийгмийн хамгаалал	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, дэд бүтэц, эрчим хүч	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спорт	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр	Эрүүл мэнд
1.	Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	<b>88</b>	6	9	<b>5</b>	19	4	9	13	12	<b>9</b>	2
2.	Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо	<b>152</b>	17	17	<b>15</b>	26	4	20	18	20	<b>12</b>	3
3.	Үүнээс Бүрэн хэрэгжсэн 100% (90-100%)	<b>121</b>	11	17	<b>15</b>	20	4	13	15	12	<b>11</b>	3
	Хэрэгжих шатанд 70% (50-89%)	<b>16</b>	-	-	-	3	-	6	1	5	<b>1</b>	-
	Хэрэгжилт хангалтгүй 30% (10-49%)	<b>4</b>	-	-	-	-	-	-	1	3	-	-
	Хэрэгжээгүй 0% (0-9%)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	<b>11</b>	6	-	-	3	-	1	1	-	-	-
Хэрэгжилтийн ерөнхий дүн, хувь		<b>94.61% буюу 4.73 оноо</b>	100% буюу 5.0 оноо	100% буюу 5.0 оноо	<b>100% буюу 5.0 оноо</b>	96.08% буюу 4.80 оноо	100% буюу 5.0 оноо	90.52% буюу 4.50 оноо	94.11% буюу 4.70 оноо	82.0% буюу 4.10 оноо	<b>97.50% буюу 4.80 оноо</b>	100% буюу 5.0 оноо

2017-2020 онуудад хяналтад авсан шийдвэрийг зохицуулалтын салбараар нь харьцуулж харуулбал: *(тухайн жилийн эцсийн байдлаар)*

Он	Зохицуулалтын салбараар, үүнээс												
	Ерөнхий чиг үүргийн салбар	Байгаль орчин аялал жуулчлал	Санхүү хөрөнгө оруулалт	Хууль эрх зүй	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэр	Батлан хамгаалах, гамшгаас урьд-Сэргийлэх	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, дэд бүтэц	Боловсрол соёл шинжлэх ухаан спорт	Зам тээвэр хөгжил	Хөдөлмөр нийгмийн хамгаалал	Эрүүл мэнд	Уул уурхай	Эрчим хүч
2017 он	25	17	10	6	<b>15</b>	<b>2</b>	7	4	4	<b>5</b>	10	0	1
2018 он	44	18	7	24	<b>18</b>	<b>9</b>	9	5	3	<b>5</b>	6	1	0
2019 он	30	15	2	1	<b>18</b>	<b>6</b>	8	8	4	<b>4</b>	3	0	0
2020 он	28	18	29	7	<b>28</b>	<b>17</b>	0	12	1	<b>20</b>	6	1	2
<b>2021 он</b>	<b>17</b>	<b>17</b>	<b>26</b>	<b>4</b>	<b>12</b>	<b>15</b>	<b>18</b>	<b>20</b>	-	<b>20</b>	<b>3</b>	-	-

2017-2021 онуудад:

1. Байгаль орчин, аялал жуулчлал,
2. Зам тээвэр хөгжил,
3. Уул уурхай,
4. Эрүүл мэнд,
5. Эрчим хүчний салбаруудын чиг үүрэгт хамаарах хяналтад авахыг үүрэг болгосон заалтууд харьцангуй тогтвортой байна.

Харин дараах салбаруудын хувьд хяналтад авахыг үүрэг болгосон заалтын тооны зөрүү ихтэй байгаа нь харагдаж байна. Үүнд тухайлбал:

1. Ерөнхий чиг үүрэг,
2. Төлөвлөлт санхүү, хөрөнгө оруулалт,
3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, дэд бүтэц,
4. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт,
5. Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын чиг үүрэгт хамаарах заалтын тоо хамгийн багадаа 5, хамгийн ихдээ 27-оор зөрүүтэй байна.

#### **Дөрөв. Хэрэгжээгүй шалтгаан, цаашид хэрэгжүүлэх гарц шийдлийн санал:**

1. Хэрэгжилт хангалтгүйгээр буюу 30%-иар үнэлэгдсэн: 4 заалтаас 1 заалтын хэрэгжилтийг хангуулахад онцгой анхаарч ажиллах,

- Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр 23 дугаар тэмдэглэл XIII.1.2. “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг нийцүүлэн боловсруулах, шинэчлэн батлуулах ажлыг эрчимжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов”

Журмын 6.6-д дагуу 2 удаагийн тайлангийн хугацаанд дараалан ахицгүй гараагүй тул удааширсан заалтаар тооцож байна.

**Тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа:** Аймгийн ГЗБЕТ-г нийцүүлэн тодотгох шаардлагатай арга хэмжээг тодорхойлж, мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх зардлын тооцоог гаргасан.

**Хэрэгжээгүй шалтгаан нь:** Санхүүжилтийн асуудал /35.0 сая/

**Гарц, шийдэл:** Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан, хэрэв санхүүжилт төсвийн төсөлд суулган, шийдэгдвэл 2023 оноос хэрэгжих боломжтой,

2. Засгийн газрын 2020-12-16-ны өдрийн Дугаар 226 дугаар Яслийн үйлчилгээний тухай тогтоолын Заалт 4.

- “Яслийн үйлчилгээний орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилт, хөрөнгө оруулалтын зардлыг орон нутгийн төсөвт тусгах, хүний нөөцийн чиглэлээр сургалт, зохион байгуулах, бага насны хүүхэдтэй эхчүүдийн хөдөлмөр эрхлэлт, ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай”

**Тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа:** Орон нутгийн БСУГ-ын зүгээс “Төрийн өмчийн цэцэрлэгийн дэргэд яслийн бүлэг ажиллуулах түр

мөрдөх журам”-д саналыг яамны сургуулийн өмнөх боловсролын газарт, Яслийн бүлэг ажиллах боломжтой (зориулалтын яслийн ангитай) 12 бүлэгтэй цэцэрлэгийг аймгийн хүн амын төвлөрөл ихтэй хороололд байрлах Дархан сумын 7,18,21,22 дугаар цэцэрлэгүүдийг санал болгон тус тус хүргүүлсэн байна.

**Хэрэгжээгүй шалтгаан:** БШУЯамны удирдлага, зохион байгуулалтаас шууд хамаарсан, эрх зүйн орчин бүрдээгүй.

**Гарц, шийдэл:** Яслийн бүлэг ажиллуулах эрх зүйн орчин бүрдсэн тохиолдолд орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх хүний нөөц, анги танхимын гэх мэт нөөцүүд байна. Цаашид хэрэгжих боломжтой.

3. Засгийн газрын 2021.10.20-ны өдрийн Дугаар 321 дүгээр “Их, дээд сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын:

- Заалт 3. “Орон нутаг дахь төрийн өмчит их, дээд сургуульд ажиллаж байгаа багш, ажилтны нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан бол зохих тэтгэмж олгох, хөнгөлөлттэй зээлд хамруулдаг байх зохицуулалт бий болгох асуудлыг судлан, эрх зүйн орчныг бүрдүүлэх, шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улс, орон нутгийн төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.”
- Заалт 4. “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг орон нутагт хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, сургалтын хөтөлбөрийн давхардлыг арилгах, тухайн орон нутгийн онцлог, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон хот, тосгоны батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төв, орон нутаг дахь их сургуулийн хотхоны техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, газар олголт, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

**Тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа:** Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил хийгдэж эхэлж байгаа.

**Хэрэгжээгүй шалтгаан:** Хугацааны хувьд боломжгүй.

**Гарц, шийдэл:** Аймгийн ЗДТГ-ын НБХэлтэс бодлогоор удирдан зохион байгуулж, Төрийн захиргааны төв байгууллага буюу БШУ-ны Сайдын тушаалаар байгуулагдсан ашиглалтын өмнөх захиргаа болон ХОХБТХэлтэс, аймгийн Захирагчийн ажлын алба, аймгийн ГХБХБГазар, аймгийн их дээд мэргэжлийн сургуулиудын концерциум болон бусад холбогдох мэргэжлийн байгуулагууд, судлаачдын багтай хамтран өргөн хүрээнд ажлын хэсгийг байгуулж ажиллах нь үр дүнтэй гэсэн саналыг уламжилж байна.

**Тав. Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хяналтнаас хасаж, орон нутгийн хяналтад авахаар хүргүүлж буй санал:**

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 03 сарын 31-ний өдрийн хуралдааны 21 дүгээр тэмдэглэлийн Заалт 4 **“хэрэгжилт нь тогтмолжсон, бүрэн хэрэгжсэн, нэг удаагийн шинжтэй буюу цаг үеийн шинжтэй** шийдвэр, заалтыг хяналтнаас хасуулахдаа хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн санд зохих тэмдэглэгээ хийж байх” гэсэн чиглэлийн дагуу: хасах саналтай 6 заалтын дэлгэрэнгүй тайлбарыг цахим санд оруулан, баталгаажуулсан.

Д/Д	ШИЙДВЭР	ЗААЛТ	ТАЙЛБАР
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 2 БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, УУЛ УУРХАЙ</b>			
1.	2020 оны 9 дүгээр сарын 23-ний өдөр 51 дүгээр тэмдэглэл 2020-09-23 Дугаар 2020_51	12. Дархан-Уул аймагт хэрэгжих уул уурхай, металлургын цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор .....үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зориулалтаар <b>газар ашиглах эрхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох</b> арга хэмжээ авахыг Дархан-Уул аймгийн Засаг даргад.....	Газрын асуудлыг бүрэн шийдвэрлэсэн буюу бүрэн хэрэгжүүлсэн тул хасах
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 4 САНХҮҮ, ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>			
2.	2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 19 дүгээр тэмдэглэл 2021-03-24 Дугаар 2021_19	II. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” асуудлыг хэлэлцээд Засгийн газрын тогтоол гаргахаар тогтов. 2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай тайлан, үнэлгээний дүнг хэлэлцэн дэмжээд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар <b>2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг</b> зориулалтын дагуу зарцуулах, хууль, тогтоолд заасны дагуу эрх шилжүүлэн зохион байгуулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгав.	Төсвийн жилдээ багтаан бүрэн хэрэгжүүлсэн тул хяналтаас хасах
3	2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр 22 дугаар тэмдэглэл 2021-04-07 Дугаар 2021_22	IX.3.2. Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан цахим систем бүхий аргачлалын дагуу боловсруулах, холбогдох бэлтгэл ажлыг <b>2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлүүлэхийг</b> Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	Тогтоосон хугацаанд хэрэгжүүлсэн тул хяналтнаас хасах
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 5 НИЙГМИЙН ХАМГААЛАЛ</b>			
4	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	18.1.3. Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, <b>түр хамгаалах байр байгуулах;</b> (18.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Бүрэн хэрэгжүүлсэн (2018 онд) тул хяналтнаас хасах
		19.1.6. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг <b>хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;</b> 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:	Бүрэн хэрэгжүүлсэн тул хяналтнаас хасах
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 6 ХУУЛЬ ЭРХ ЗҮИ</b>			

5	2021 оны 3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03 Дугаар 2021_14	ХИ.2.4. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Улсын Их Хурал, Засгийн газраас батлахаар хуульчилсан журмын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, <b>саналаа хүргүүлэхийг</b> аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Бүрэн хэрэгжүүлсэн тул хяналтнаас хасах
<b>5 шийдвэрийн 6 заалт</b>			

ТАНИЛЦСАН:  
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА Д. ЖАРГАЛСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН